

5

АУДИТЫН КОМПАНИУДЫН БАЛАНСЫН ШИНЖИЛГЭЭНД ҮНДЭСЛЭСЭН ҮР АШГИЙН ТООЦООЛОЛ

Л.Мөнх-Очир. Ж.Ариунболд

Энэхүү судалгааны ажлаас гарсан үнэлэлт, дүгнэлт нь тус судалгааг хийж гүйцэтгэсэн судлаачдын байр суурийг илэрхийлнэ. Тус судалгаатай холбоотой аливаа санал, зөвлөмж, шүүмжийг хүлээн авахдаа бид таатай байх болно.

Хураангуй

Тус судалгааны ажил нь дэлхийн банк болон олон улсын шинжээчдийн хэрэглэдэг **CAMELS** аргачлалд тулгуурласан болно. Ингэхдээ нийт 13 аудитын компаний 2007-2010 оны санхүүгийн тайланд үндэслэн Панел үнэлгээний аргачлал ашиглаж үнэлгээ хийлээ. **CAMELS** аргачлаар үндсэн 6 үзүүлэлт хэр чухал болохыг харуулахын тулд дээрх аудитын компаниудын үр ашигт хэрхэн нөлөөлснийг харуулсан болно. Санхүүгийн мэдлэгтэй аудитын компаниудын харилцагчдын төсөөлөл дэх аудитын санхүүгийн байдал нь бодит үзүүлэлттэй хэр зөрүүтэй байгааг үзүүллээ. Ингэснээрээ аудитын компаниуд харилцагчдынхаа өмнө хэр зэрэг нээлттэй байгааг, нөгөө талаараа аудитын компаний харилцагчид өөрийн үйлчлүүлдэг аудитын компаний талаар хэр мэдлэгтэй болохыг шинжилж, мэдээллийн түгэлт ямар түвшинд байгааг харуулсан болно. Мөн аудитын компаниудын үр ашигт хүчтэй нөлөөлж байгаа 2 хувьсагчийг сонгон авч, түүгээр аудитын компаниудын матрицийг зохион, тогтвортой болон тогтворгүй үйл ажиллагаатай аудитын компаниудыг CE матрицаар харууллаа.

Бидний авч үзсэн үнэлгээний загвар, судалгааны үр дүнд санхүүгийн үзүүлэлтүүд аудитын компаний үр ашигт хүчтэй нөлөөлдөг болох нь батлагдсан юм. Мөн аудитын компаниуд илүү үр ашигтай ажиллах боломжтой, аудитын компаний харилцагчид бүрэн дүүрэн мэддэггүй зэрэг дүгнэлтэнд хүрлээ.

ОРШИЛ

Монгол улсад аудитын салбар үүсч хөгжөөд 17 дахь жилтэйгээ золгож байна. Гадаад улс орнуудад аудитын хөгжлийн төлөв байдлыг дараах байдлаар тодорхойлж байна.

1. Аудит нь онолын хувьд хөгжиж загвар тогтсон. Энэ үйл ажиллагаа даяарчлагдсан
2. Аудитын үйл ажиллагааг хэт төвлөрч үйл ажиллагаанд нь сөрөг хандлага бий болсон
3. Үндэстэн дамнасан компаниудын үйл ажиллагаа хэт төвлөрөл нь аудитын үйл ажиллагаанд гажуудал бий болгов
4. Аудитын үйл ажиллагаанд тавих төрийн хяналт нэмэгдэх болов.

Гадны орны байдлаас харахад, харилцагчид нь аудитын клмпаниа эргүүлэн хянадаг, нөгөө талаас аудитын компаниуд харилцагчдаа алдахгүйн тулд санхүүгийн тогтвортой үйл ажиллагаагаа хангахыг эрмэлздэг байна.Энэ нь зах зээлийн хуулийн дагуу аудитын компаний оршин байх нь харилцагчдаас шууд хамаарсан байгааг харуулж байна. Аудитын компаниуд нэгдэх, тэр ч бүү хэл бүтцээрээ нэгдэх асуудал сүүлийн жилүүдэд ажиглагдаж байна. Энэ нь мөн л аудитын компаниуд үр ашгаа тогтвортой барихын тулд харилцагчдаа алдахгүй байх оролдлого юм. Аудитын компаниудын хувьд найдвартай тогтвортой харилцагч ихээхэн чухал байдаг. Харилцагчид өөрийн аудитын компанийг эргүүлэн хянах тогтолцоо манайд дутагдалтай байна. Хэдийгээр аудитын компаниуд санхүүгийн тайлангаа ММНБИ, болон сангийн яаманд өгдөгч мэдээллийн хомс байдлаас болоод өөрч хэрэгтэй мэдээлэлээ авч чаддаггүй зарим талаараа сонирхдогч үгүй байна. Үүнээс шалтгаалж аудитын компаниудын харилцагчдынхаа өмнө хариуцлагатай байх үндэс суурь алдагдсаар байна. Эдийг засаг нь тогтворжоогүй, хөгжиж буй орнуудын хувьд аудитын компаниудын хямрал нь сөрөг нөлөө ихтэй юм. Аудитын компаниудыг ямар байдалтай байгааг мэдэж болох зүйл нь санхүүгийн үзүүлэлтийн динамик юм. Ийм учраас санхүүгийн үзүүлэлтүүдийг динамикийг анхаарах нь зүйтэй. Бид уг судалгаагаараа санхүүгийн ямар ямар үзүүлэлтүүд нь аудитын компаниудын үр ашигт чухал нөлөөтэй байгааг, мөн санхүүгийн үзүүлэлтүүдээ алдагдуулснаар дампуурах аюулд хүрдэг болох, Мөн том дунд жижиг аудитын компаниудын үр ашиг ялгаатай байгааг харуулахыг зорилоо. Харилцагчдаас тухайн аудитын компаний талаар хэр бодитой төсөөлж байгааг, өөрөөр хэлбэл харилцагчдаас авсан мэдээллийг бодит үр дүнтэй харцуулалт хийж харууллаа.Ингэснээрээ аль аудитын компаний харилцагчдынхаа төсөөлөлтэй илүү дөхөж байна, аль аудитын компани хол байна гэдгийг харах боломжтой. Судалгааны тооцоолол, үр дүнг E-views 6.0 Microsoft Excel 2010

програмуудыг ашиглан харууллаа. Тус судалгаа нь аудитын компаниудын тайлан тэнцэл, орлого үр дүнгийн тайланд суурилсан.

Судлагдсан байдал: Иймэрхүү төрлийн судалгаанууд нь дэлхийд анх буюу Америкт 1980-аад оны сүүлээр хийгдэж эхэлжээ. Үр ашгийн тооцооллыг хийсэн олон төрлийн судалгаа байдаг ч, шугаман программчлалын техник аргачлыг ашигласан Data envelopment analysis арга нь хамгийн анхны нарийвчилсан арга байсан юм. Уг аргыг анх Charnes, Cooper, Rhode 1978 нах санаачлан (CCR загвар) ашгийн бус байгууллагуудын хувьд үнэлгээ хийсэн байдаг.

Онолын хэсэг

CAMELS зэрэглэл тогтоох аргачлал нь холбооны нөөцийн сан, Дэлхийн банкны хянан шалгагч нарын хөгжүүлэн бий болгосон загвар юм.

Хүснэгт 1. Санхүүгийн үзүүлэлтүүдийн тооцоо.

Үзүүлэлтүүд	Харьцаа	Утга	Тэмдэг лэгээ
Capital adequacy	Өөрийн хөрөнгө/ нийт актив	Өөрийн нөөцөөр эрсдлийг даах чадвар	CR
Asset quality	Ашиг/балансын дүн	Нийт хөрөнгийн нэгжид ногдох ашгийн хэмжээ	AQ
Management	Боловсон хүчний зардал/Балансын дүн	Менежментийн зардлын түвшинг харуулна	Man
Earnings	Татварын өмнөх ашиг/Балансын дүн	Нөөцийн хүрээнд олж буй ашгийн түвшин	ROA
Liquidity	Мөнгөн хөрөнгө+ТБҮЦ+авлага/БХӨТ	Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	LR
Sensitivity to market changes	Мөнгөн хөрөнгө+ТБҮЦ/БХӨТ	Зах зээлийн эрсдлээ бууруулах чадвар	GAP
Efficiency	Ашиг/өөрийн капитал	Үр ашгийг илэрхийлэгч үзүүлэлт	ER

Тус судалгаанд авч үзсэн харьцаанууд нь хураангуй тайлангаас цуглуулсан мэдээлэлд үндэслэсэн ч санхүүгийн чиг хандлагыг ижилхэн гаргаж ирэх чадвартай юм.

CAMELS АРГАЧЛАЛЫН ТЭГШИТГЭЛИЙГ ИЛЭРХИЙЛБЭЛ:

$$Z = A_0 + A_1 CR + A_2 AQ + A_3 Man + A_4 ROA + A_5 LR + A_6 GAP$$

Тэгшитгэлийн хувьд Дээрх үзүүлэлтүүдийн гарсан утгыг нэмж 1-5 хүртэл оноог өгдөг. 1 оноо уруу тэмүүлж байвал тухайн аудитын компани сайн, харин 4, 5 байгаа бол асуудалтай компани байгааг харуулна. Харин бидний хувьд “Коэффициентын анализын аргачлал” ашиглан нийт аудитын компаниудын үнэлгээг Z оноогор харуулах юм. Аудитын компанийн үр ашгийг ашигт ажиллагаагаар тооцоолох нь төдийлөн оновчтой байдаггүй. Харин тус харьцааны гол санаа нь хэдий жижиг аудитын компани ч гэсэн нийт активын хэмжээнээс хамааралгүйгээр боловсон хүчнээ зөв шийдсэн, мөн хүүгийн бус

орлого сайтай, зэргээр үр ашгаа нэмэгдүүлж болох юм. Томоохон аудитын компаниудын хувьд хэт их тэлэлт явуулж дотоод хөрөнгө оруулалт хийснээр үр ашгаа буулгах хандлага жижиг аудитын компанийг бодвол их байдаг.

Тус шинжилгээг бид аудитын компаниудыг төлөөлүүлэн авч үзэж байгаагийн хувьд хөлгөн үнэлгээний (cross-section) аргачлал болох Панел үнэлгээний аргачлал хийж шалгах юм.

Үнэлгээний загварын хувьд:

$$Z=A_0+A_1CR+A_2AQ+A_3Man+A_4ROA+A_5LR+A_6GAP+u$$

Мөн эдгээр харьцаанууд нь банкиг дампуурахад хүргэдэг эсэхийг шинжлэхдээ магадлалын шугаман загвар ашиглах юм.

2. Коэффициентийн анализын аргачлал (КАА)

Коэффициентийн анализын аргачлал нь матрицын мөр баганы дагуух өөр хоорондоо ялгаатай, элементүүдэд коэффициент оноох замаар коэффициентүүдийг интервалд байршуулах аргыг хэлнэ.Энгийн үгээр хэлбэл цувааны хамгийн бага утгад 0 оноо өгч, хамгийн өндөр утгад 1 оноо өгч медианд 0.5 оноо өгч уг зүй тогтолоор цувааг эрэмбэлэх юм. Бид тус аргачлаар гаргасан Z оноогоор дамжуулан Kernel Density-н Epanechnikov-н аргачлалыг ашиглан үр ашигт үйл ажиллагааны тогтворжилтыг хэмжсэн болно.

3. Панел үнэлгээний загвар

Өнөөдөр панел өгөгдлийн загварыг санхүү, эконометрикийн судалгаа шинжилгээнд хэрэглэх явдал ихсэх болсон байна. Хугацааны цувааны шинжилгээ /Time Series Analysis/ болон хөлгөн өгөгдлийн шинжилгээ (Cross-sectional Analysis)-нүүд нь тус тусдаа буй судлагдахуунуудын хоорондох хамаарлын харьцангуй тогтвортой динамик өөрчлөлтийг тооцоолох, түүнд тайлбар өгөхөд нилээд өрөөсгөл байдагтай холбоотой юм. Энэхүү панел үнэлгээ авч үзэж буй өгөгдлүүдийг нэгтгэн өүхэл системээр нь үнэлж, системийн шинжилгээг хийлэг бөгөөд тэдгээрийн хоороонд гарах алдааг хамгийн бага байлгадаг зэрэг нь уг аргачлалыг сонгох үндэслэл болсон билээ. Энэхүү PDRM(Panel data regression Model) загварыг дотор нь сул гишүүнээс нь хамааруулан тогтвортой нөлөөлийн загвар, санамсаргүй нөлөөлийн загвар гэж хуваах ба эдгээрийн тэгшитгэлийг тус бүрд нь бичвэл

PDRM-ийн загварын ерөнхий тэгшитгэлийг бичвэл:

$$Y_{it}=B_1+B_2X_{2,it}+\dots\dots\dots B_kX_{k,it}+u_{i,t}$$

K=1, 2,,,,,,Тэгшитгэлийн тайлбарлагч хувьсагчдын тоо

I=1,2,3,,,,,,n загварын хөлгөн өгөгдлийн урт(жнь: аудитын компаний тоо)

T=1,2,3 ,,,,,,t хугацааны урт(сар улирал улирал жил)

Судалгааны арга зүй

Тус судалгаанд 2008 оноос 2010 оны аудитын компаниудын тайлан тэнцэл, орлого үр дүнгийн тайлан, мөн аудитын компаниар үйлчлүүлэгч байгуулагуудын хэрэглэгчийн судалгааны өгөгдөл ашиглав.

CAMELS аргачлалын 6 үзүүлэлтүүдийн нийлбэр буюу z оноог аудитын компаниудын хувьд гаргаж, түүнийгээ КАА ашиглан 0-1 гэсэн утгад

байршуулж тархалтын Kernel density-гээр дүрсэлж, дундаж утган дээрхи төвлөрлийг зургаар Х-д оруулсан. Ингэж оруулсанаар үйл ажиллагаа хэрхэн тогтворжиж байгааг мэдэж болох юм. Мөн корреляцын шинжилгээ хийж хоорондоо хүчтэй хамааралтай хувьсагчдыг тогтоолоо. Мөн аудитын компаниудад улиралын нөлөө хэр зэрэг байдгийг үнэлэх, том жижиг дунд аудитын компаниудын ялгааг гаргахын чанарын хувьсагч оруулан тооцлоо. Үр ашгийн харьцааг санхүүгийн үзүүлэлтүүдээс нь хамааруулан үнэлсэн үнэлгээнээс 2 хувьсагчийг сонгон авч, түүнийгээ матриц хэлбэрээр харуулав.

Харилцагчдийн судалгааны үр дүнгээр тодруулсан санхүүгийн 6-н үзүүлэлтүүдийн оноог 0-1 гэсэн утганд эрэмбэлж, бодит утгаа мөн КАА ашиглаж индекслэн 6-н талтай Радарт дүрслэн аудитын компани бүрийн зураглалыг Х-д харуулав.

Аудитын компаний тухай тайлан мэдээ олоцын хувьд бэрхшээлтэй байлаа.

Судалгааны хэсэг

1. Корреляцын шинжилгээ

Хувьсагчид хоорондоо нягт хамааралтай ($0.9 < \text{corr} < 1$) байгаа эсэхийг тодрууллаа үүний үр дүнд өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон GAP харьцаа нь хоорондоо 93 хувийн шууд хамааралтай гарсан байна. Мөн өөрийн хөрөнгийн хүрэлцээ нь хөрвөх чадварын харьцаатай хүчтэй хамааралтай буюу 84 хувийн хамааралтай байгаа нь эцсийн үнэлгээндээ өөрийн хөрөнгийг хасч тооцох нь үр дүнтэй болохыг харуулж байна.

	ER	CR	AQ	MAN	ROA	LR
CR	-0.59					
AQ	-0.49	0.55				
MAN	-0.39	0.09	0.23			
ROA	0.69	-0.29	-0.51	-0.45		
LR	-0.65	0.84	0.58	0.07	-0.38	
GAP	-0.60	0.93	0.52	0.04	-0.26	0.83

2. Панел үнэлгээний нөлөөлөөр үнэлэх нь

Эконометрикийн шинжилгээ хийдэг Eviews 6.0 программаар тооцон үзлээ.

Dependent Variable: ER

Method: ML – PANEL LEAST SQUARES

Date: 05/02/11 Time: 02:05

Sample: 2008

Included observations: 156

Covariance matrix computed using second derivatives

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
CR	-0.439	0.198	-2.223	0.0000
AQ	0.575	0.153	3.755	0.0000
MAN	-6.539	1.370	-4.774	0.0000
ROA	5.796	0.812	7.135	0.0000
LR	-0.150	0.079	-1.891	0.0000
ER(-1)	0.264	0.063	4.221	0.0000
C	0.618	0.064	9.625	0.0000
R-squared	0.8484	Mean dependent var	0.618	
Adjusted R-squared	0.8135	S.D. dependent var	0.3444	
S.E. of regression	0.1486	Akaike info criterion	0.804	
Sum squared resid	2.7813	Schwarz criterion	-0.218	
Log likelihood	92.7471	F-statistic	24.3117	
Durbin-Watson stat	2.333810	Prob(F-statistic)	0.111584	

Substituted Coefficients: =====

$$ER = -0.43*CR+0.57*AQ-6.53*MAN+5.79*ROA-0.15*LR+0.26*ER(-1)+0.61*C$$

Уг үнэлгээнд GAP харьцаанаас бусад нь статистикийн ач холбогдолтой байсан тул хасч үнэлэв. Учир нь GAP харьцаа нь өөрийн хөрөнгийн хүрэлцээтэй нягт хамааралтай байгаа билээ.

Тайлбар:

- Бусад хүчин зүйлс тогтмол байхад өөрийн хөрөнгө нэг пунктээр нэмэгдсэнээр үр ашиг 0.43 нэгжээр буурах хандлагатай байна.
- AQ нь бага байх тусмаа сайн байдаг. Орлого олох нэгж нь нэг пунктээр нэмэгдсэнээр үр ашиг 0.57 нэгжээр өсөх хандлагатай байна
- Бусад хүчин зүйл тогтмол байхад менежментийн зардал нэг пунктээр нэмэгдсэнээр үр ашиг -6.53 нэгжээр буурч байна. Цалингаа нэмэгдүүлсэнээр, боловсон хүчний орон тоогоо нэмсэнээр үр ашиг буурч байна.
- Бусад хүчин зүйлс тогтмол байхад ашигт ажиллагаа нь нэг пунктээр нэмэгдсэнээр үр ашиг 5.79 нэгжээр нэмэгдэж байна.
- Хөрвөх чадвар буюу төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нь 1 пунктээр нэмэгдсэнээр үр ашиг 0.15 нэгжээр буурч байна.

3. Улиралын нөлөөлөл

Аудитын компаниудын үр ашигт улиралын нөлөө бий эсэхийг шалгахын тулд нэг жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг авч үзлээ.

Dependent Variable: ER
 Method: ML – PANEL LEAST SQUARES
 Date: 05/02/11 Time: 02:05
 Sample: 2009Q4
 Included observations: 12
 Covariance matrix computed using second derivatives

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
AQ	0.348	0.139	2.505	0.0000
MAN	-4.950	1.122	-4.410	0.0000
ROA	5.971	0.715	8.353	0.0000
LR	-0.172	0.061	-2.797	0.0000
GAP	-0.240	0.117	-2.046	0.0000
ER(-1)	0.327	0.060	5.438	0.0000
SEAS(1)	0.546	0.061	9.022	0.0000
SEAS(2)	0.474	0.058	8.138	0.0000
SEAS(3)	0.523	0.056	9.338	0.0000
SEAS(4)	0.549	0.062	8.900	0.0000

R-squared	0.791	Mean dependent var	0.6178
Adjusted R-squared	0.778	S.D. dependent var	0.3440
S.E. of regression	0.162	Akaike info criterion	-0.7386
Sum squared resid	3.839	Schwarz criterion	-0.5431
Log likelihood	67.612	F-statistic	24.3117
Durbin-Watson stat	1.810	Prob(F-statistic)	0.11158

Үнэлгээний үр дүнг харуулбал

$$ER = 0.34AQ - 4.94MAN + 5.97ROA - 0.17LR - 0.23GAP + 0.32ER(-1) + 0.546SEAS(1) + 0.47SEAS(2) + 0.52SEAS(3) + 0.549SEAS(4)$$

2-р улиралд хамгийн бага үр ашигтай ажилладаг байна. Улиралын нөлөөлийн мэдрэмж ойролцоо байгаа нь аудитын компаниуд улиралын нөлөөлөлөөс хүчтэй хамаардаггүй болох нь харагдаж байна.

4. Аудитын компаниудын зах зээлд эзлэх хувь хэмжээ

Аудитын үйл ажиллагаа явуулж буй компаниудыг активын хэмжээ болон олон улсад үйл ажиллагаа явуулж буй цар хүрээгээр нь Том(Эрнест, Нимм, Далайван, гм), дунд (нийслэл, Мэдээлэл, тэнцвэр оргил гм), жижиг (их наяд, баталгаа, энич гм) ангилж чанарын хувьсагч хийнэ үнэлгээ хийлээ.

Dependent Variable: ER
 Method: ML – PANEL LEAST SQUARES
 Date: 05/02/11 Time: 01:05
 Sample: 2008-2010

Included observations: 12

Covariance matrix computed using second derivatives

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
AQ	0.385	0.140	2.744	0.0000
MAN	-4.603	1.113	-4.135	0.0000
ROA	6.350	0.724	8.773	0.0000
LR	-0.238	0.043	-5.518	0.0000
D1	0.486	0.064	7.633	0.0000
D2	0.553	0.059	9.310	0.0000
D3	0.489	0.055	8.862	0.0000
ER (-1)	-0.339	0.060	5.638	0.0000

R-squared	0.784094	Mean dependent var	0.61784
Adjusted R-squared	0.773882	S.D. dependent var	0.3440
S.E. of regression	0.163587	Akaike info criterion	-0.7386
Sum squared resid	3.960506	Schwarz criterion	-0.5431
Log likelihood	65.17541	F-statistic	24.3117
Durbin-Watson stat	1.891698	Prob(F-statistic)	0.11158

$$ER=0.38AQ-4.6MAN+6.35ROA-0.23LR+0.33ER(-1)+0.486D1+0.55D2+0.489D3$$

Аудитын компаниудын хувьд дунд аудитын компаниуд жижиг, том аудитын компаниудыг бодвол илүү үр ашигтай ажиллаж байна. Энэ том аудитын компаниуд түрээс болон, менежментийн зардал өндөр, харин жижиг компаниуд харилцагч цөөн байгаатай холбоотой байна.

5. Аудитын компаниудыг GE-ийн матриц болон дундаж төвт графикаар шинжлэх нь

Монголын аудитын салбарын үр ашгийг нэлээд өндөр хувьтайгаар тайлбарлаж буй өөр хоорондоо ялгаатай 3-н үзүүлэлт болох ROA, CR, LR –уудыг сонгон авч ROA-CR, болон ROA-LR гэсэн хослолоор компаниудыг дундаж төвт матрицын тусламжтайгаар графикт байршуулсан.

1. Аудитын компаниудын хувьд дээрх үзүүлэлтүүд хугацааны хувьд хэр тогтвортой байгааг
2. Тухайн аудитын компани нийт аудитын салбарын дундаж үзүүлэлттэй харьцуулахад хэр сайн эсвэл муу байгааг гэсэн хоёр тохиолдолд аудитын компаниудыг тодорхойлох юм.

ROA-CR, LR(Тогтвортой байдлын шинжилгээ)

Хүснэгт 2. Аудитын компаниудыг матрицан байршил

ROA

		Ерөнхийдөө өсөлттэй		Тогтонги		Бууралттай	
		Савалгаа өндөртэй	Тогтворжих хандлагатай	Савалгаа өндөртэй	Тогтворжих хандлагатай	Савалгаа өндөртэй	Тогтворжих хандлагатай
CR	Өсөлттэй	Савалгаа өндөртэй					
		Тогтворжих хандлагатай	Мэдээлэл	Б энд С	Бизкон		Нимм ситико
	Тогтонги	Савалгаа өндөртэй	Жонон ван Координат		нийслэл	итгэлт	Сүлд
		Тогтворжих хандлагатай			Эс эм	Эрнест Далайван	
Бууралттай	Савалгаа өндөртэй			Баталгаа онош	Энич аудит Бисофт		
	Тогтворжих хандлагатай					Онч	
LR	Өсөлттэй	Савалгаа өндөртэй	Мэдээлэл	Б энд С			Энич аудит
		Тогтворжих хандлагатай			Бизкон	Эрнест далайван	
	Тогтонги	Савалгаа өндөртэй			нийслэл	Итгэлт	Нимм ситико
		Тогтворжих хандлагатай	Жонон ван Координат		Бисофт аудит		
Бууралттай	Савалгаа өндөртэй			Эс эм	Баталгаа онош		Онч Тэнцвэр оргил
	Тогтворжих хандлагатай					Сүлд	

6. Мэдээллийн түгэлтийг Радар зураглалаар хэмжих нь

Хэрэглэгчдийн судалгааг аудитын компаниудын одоо байгаа бодит байдалтай харьцуулснаар 1-рт аудитын салбарт мэдээлэл хэр үнэн бодитой тархсан эсэх, 2-рт аудитын компани үйлчлүүлэгчдийнхээ өмнө хэр нээлттэй ажилдагийг шинжилж, үнэлэлт дүгнэлт өгөх боломжтой. Үүнийг аудитын компаниудын бодит үр дүн (баланс) суурь болгон авч харилцагчын мэдээлэлтэй харьцуулах замаар хүснэгтэн мэдээллээр авч үзье.

	CR	AQ	MAN	ROA	LR	GAP
Эрнест	-	=	+	=	+	=
Итгэлт	-	+	+	=	-	-
Нимм	+	+	-	=	-	=
Ситико	-	-	-	+	+	=
Жононван	-	-	-	-	+	=
Координат	+	-	-	+	-	+
Сүлд	-	-	-	+	-	+
Тэнцвэр оргил	-	-	-	+	-	+
Онч	+	-	-	+	+	+
Энич аудит	+	-	-	+	-	-
Бисофт	+	+	-	+	+	-
Бизкон	=	-	=	-	-;	=
Эс эм	+	-	-	+	-	+
Мэдээлэл	=	-	-	+	-	+

Дээрх хүснэгтээс харахад Эрнест ХХК-ны талаарх харилцагч нарынх нь мэдээлэл бодит байдалтай ерөнхийдөө таардаг буюу зарим нэг үзүүлэлт нь хүмүүсийн бодож байгаагаас илүү сайн байна.

Ситико ХХК-ын хувьд харин эсрэгээрээ харилцагчид нь илүү өндрөөр үнэлж байдаг боловч бодит байдал дээр тэдний хүлээлтээс арай бага байх нь давамгайлж байна.

Нийт системд мэдээлэл хэр зэрэг тархсаныг харьж болох юм. Эндээс харвал харилцагчид аудитын компаниудыг өөрийн хөрөнгийн хүрэлцээ сайн, ашигт ажиллагаа өндөр, мөн зах зээлд эрсдэл хүлээх чадвар өндөр хэмээн үздэг нь бодит байдлаас дээгүүр үнэлж байна.

Харин Менежментийн зардал, хөрвөх чадварын харьцаа гэсэн үзүүлэлтүүдийн хувьд хүмүүсийн мэдээлэл бодит байдлаас доогуур үнэлэмжтэй байдаг байна.

Дүгнэлт

Нийт аудитын компаниудын үр ашигт байдал болон тус судалгааны өмнө тавьсан зорилго, зорилтууддаа хүрч чадлаа гэж үзэж байна.

Судалгааны үр дүн болон судалгаа хийх явцад олж мэдсэн зүйлүүдээсээ дараах хэд хэдэн дүгнэлтүүдийг гаргаж байна.

- Панел үнэлгээгээр үнэлэхэд аудитын компаниудын хугацааны нөлөөлөл харьцангуй тогтвортой байгаа нь аудитын компаниуд тогтворжиж байгааг харуулж байна

- CAMELS АРГАЧЛАЛЫН санхүүгийн үзүүлэлтүүд аудитын үр ашигт нөлөөлж байгаа нь статистикийн үнэлгээгээр батлагдсан нь чухал хэмжүүр болохыг харуулж байна.
- Аудитын компаниуд санхүүгийн нөхцөл байдлаа сайжруулсанаар үр ашгаа нэмэгдүүлэх боломж байгаа нь харагдаж байна.
- Аудитын компаний үр ашиг төдийлөн сайн биш байгаа бөгөөд зарим аудитын компаниудын хувьд санхүүгийн байдал нь савалгаа өндөртэй байна.
- Аудитын компаниуд үйл ажиллагаагаа таниулах тал дээр дутмаг байгаа нь харагдаж байна. Үйлчлүүлэгч нар өөр өөрийн түвшинд харилцан адилгүй мэдээлэлтэй байна.

Санал зөвлөмж

Энэхүү судалгааны агуулга, тавьсан зорилгодоо хүрсэн байдлаас шалтгаалж дараах зөвлөмжүүдийг санал болгож байна.

- ММНБИ-ийн хувьд аудитын компаниудыг сайтар хянаж, чиглүүлэх арга замаа сайжруулах хэрэгтэй
- Томоохон аудитын компаниуд үр ашгаа нэмэгдүүлэхийн тулд менежментийн зардлаа бууруулах хэрэгтэй
- Жижиг компаниудын хувьд харилцагч нартай илүү нээлттэй ажиллаж, өөрийн нэр хүндээ анхаарах хэрэгтэй
- Аудитын компаниудын өөрийн онцлогт таарсан оновчтой стратеги боловсруулах хэрэгтэй
- Үйлчлүүлэгч нар өөрийн үйлчлүүлж буй аудитын компаниа хянаж, санхүүгийн байдлыг нь мэдэж байх хэрэгтэй
- Аудитын компаниудын талаар судалгаа хийхдээ нийт системээр нь авч үзэх хэрэгтэй байна.

Ном зүй.

1. Efficiency ratio and Community bank Performance. Fred H.Hays, Stephen A.De Lurgio, Arthur H.Gilbert, Jr. Kansas: s.n., Journal of finance and Accountancy, p. 15
2. Ж.Ариунболд: Нягтлан бодох бүртгэлийн багш нарын эрдэм шинжилгээний бүтээл 2009 “Монголын аудитын салбарын байршлын хувилбар сонголт”
3. Ж. Ариунболд: Нягтлан бодох бүртгэл аудитын тулгамдсан асуудлууд - 2010 “Тэтгэврийн нэрийн дансыг хөрөнгийн зах зээлд татан оруулах нь”
4. Ж. Ариунболд: Багш нарын эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл 2011 “Монголын хувьцаат компаниуда тохирсон дампуурлын эрсдлийн загвар”